

**“САКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-ИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЧАНДМАНЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ ЗЭЭГТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН  
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: 000905А, 11965А,  
14217А, 17438А/

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 2862468/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын Ахлах мэргэжилтэн .....

Биелэлтийг тайлагнасан:

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн  
Үйл ажиллагаа хариуцсан захирал

/М.Баярманла/

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн  
Байгаль орчны мэргэжилтэн

/А.Хандмаа/

2022 он

## АГУУЛГА

<b>НЭГ. УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	2
1.1. Төслийн товч танилцуулга.....	2
1.2. Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллагааны бүдүүвч схем .....	3
1.3. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт .....	4
1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	5
1.5. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал.....	5
1.6. Усны хэрэглээ .....	8
<b>ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	9
2.1. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
2.2. Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа .....	11
2.3. 2022 оны төлөвлөгөөний гол зорилтын биелэлт .....	13
2.4. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
<b>ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	27
<b>ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	27
<b>ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	2
<b>ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	2
<b>ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	4
<b>НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	14
<b>ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</b> .....	17
<b>АРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ</b> .....	17
<b>АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	17
<b>ДҮГНЭЛТ</b> .....	19
<b>ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД</b> .....	22

## НЭГ. УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн товч танилцуулга

“Сакер Ресорсус Монголиа” ХХК нь Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших Шар хоолой хэмээх нэртэй газарт ашигт малтмал ашиглалтын 905А, 11965А, 14217А тоот тусгай зөвшөөрөл бүхий 483.53 га талбайг эзлэн байрлана. Орд нь Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны уулс хоорондын хотгорын нэг болох Шар хоолойн хотгорт далайн түвшнээс дээш 2300 гаруй метрийн өндөрт байрлана.

Тус уурхай нь 1979 оноос ашиглалт явуулж ирсэн бөгөөд 1994 онд хувьчлагдан 2006 оноос манай компани тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж байна. Анх 1969 онд Зээгтийн нүүрсний ордод эрэл хайгуулын ажил явуулсан (Д.Дашцэрэн нар ) ба нүүрсний 4.48 сая тонн нөөц тооцсон. Энэ үед 7 канав, 20 шурф, 18 цооногийн өрөмдлөгийн ажил хийсэн байна.

1979 овд Д.Оросоогийн удирдсан анги ордод нарийвчилсан хайгуул хийсэн. Нарийвчилсан хайгуулаар 10 канав, 133 шурф (116 шурфыг нөөцийн тооцоонд ашигласан), 54 цооногийн өрөмдлөг (50 цооногийг нөөцийг тооцоонд ашигласан)-н ажил хийж, балансын нөөц болон урьдчилан үнэлсэн, таамаг нөөцүүдийн тооцоо хийжээ.

Үүнээс хойш тус ордод нарийвчилсан ба ашиглалтын хайгуулын нэмэлт ажил явагдаагүй ба 2005 онд “Түлш-Алтай” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 2006 оноос “Сакер Ресорсус Монголиа” ХХК нөөц өсгөх нарийвчилсан хайгуулын ажлыг хийж эхэлсэн.

Зураг №1.Талбайн байршил



“Сакер Ресорсус Монголиа” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын

нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх зорилготойгоор ажиллаж байна.

2012 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2013 онд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг ашиглалтын талбайнуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулж холбогдох байгууллагаар батлуулсан.

Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 2011 оноос эхлэн археологийн хайгуул судалгаа, 2012 онд археологийн малтлага судалгааны ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлсэн.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон биелэлтийг БОАЖЯ-аар жил бүр батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.

## 1.2. Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллагааны бүдүүвч схем

Одоогоор тус уурхай нь Говь-Алтай аймаг болон сум, орон нутгийн дулааны хэрэгцээнд зориулж бага хэмжээний нүүрс олборлож байна. Хөрс хуулалт болон нүүрс олборлолтод ойролцоогоор 1-1,5 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай экскаватор сонгон ажиллуулдаг тул нүүрсний доголын өндөр 5 метр, арлын өргөн нь 10-15 метр байна.

### Ажлын талбайн өргөн

$$B_{am}^0 = B_H + c_1 + T_z + c_2 + z = 16.5 + 2 + 15 + 2 + 0.51 = 36.01 \text{ м}$$

Үүнд:

$B_H$  – нурлын өргөн , м

$c_1$ - нурлын ирмэгээс машин замын ирмэг хүртлэх зай, м

$T_z$ - замын өргөн, м

$c_2$  – аюулгүйн зай, м


$z$  – нурлын призмын өргөн, м

$$z = H_d * (\text{ctg } \alpha_0'' - \text{ctg } \alpha_0) = 5 * (\text{ctg } 65^0 - \text{ctg } 70^0) = 0.51$$

### Уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Нүүрсэнд ажиллах механикжуулалтын бүтэц нь Эксваци-Автотээвэр байх бөгөөд Эксватор-автосамосвал иж бүрдэлтэйгээр ажиллана. Тээвэртэй хөрс хуулалтад Эксваци - Тээвэр-Овоолго гэсэн бүтэцтэй байх бөгөөд Экскаватор-автосамосвал-бульдозер иж бүрдлээр ажиллана. Уурхай I болон IV улиралд ажилладаг ба шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг тухай бүрд нь түрээсээр авч ажиллуулах ба түрээсийн төлбөр , дизель

түлшний зардлаас бусад сэлбэг хэрэгсэл, элэгдлийн зардал нь түрээслэгч тал хариуцах болно.



**CAT-3250 марайн урвуу утгуурт экскаватор техникийн үзүүлэлтүүд**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тэмдэглэгээ	CAT-3250
1.	Уттуурын багтаамж	м		1.6
2.	Жин	ТОНН		21.3
3.	Утталт хийх хамгийн их зай	м	В	9.8
4.	Байршлын түвшин дэх тах зай	м	с	10.1
5.	Ухалтын гүн	м	А	9.5
6.	Ухах хамгийн их өндөр	м	Е	10.5
7.	Ашх өндөр	м	О	8.0
8.	Түвшний савны багтаамж	л		740
9.	Түлш зарцуулалт (дунд)	л/ц		31.0
10.	Явах хурд	км/цаг		5.0

### 1.3. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

Тус уурхай нь 1979 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа Зээгтийн уурхайгаас ойролцоох сумуудад нүүрс авах зайлшгүй шаардлагатайг учир манай компани түрээсийн техник, тоног төхөөрөмжөөр нүүрс олборлон нийлүүлж байна.

### Хүснэгт-1. 2022 онд уурхайд ажиллах техник тоног төхөөрөмжийн бүтээл

Нэр	Марк	Хүчин чадал	Тоо.ш	Ээлж бүт м <sup>3</sup>	Сар бүт м <sup>3</sup>
Экскаватор	CAT-325O	125 kW	1	1,800.0	108000
Өөрөө буулгагч Автосамосвал	16-18 м3	6200/V8	3	357.0	64260
Авто ачигч	3 м3	-	1		

#### 1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

##### Нүүрс олборлолт

Нүүрс олборлолтын ажлыг 2022 онд ордын нүүрсний гаршийн суналын дагуу өмнө үүссэн уурхайн карьерыг үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөв. 2022 оны 10 дугаар сард 25.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 3.0 мян тонноос хэтрэхгүй нүүрс олборлохоор төлөвлөв.

Нүүрс борлуулалтыг орон нутгийн байгууллагуудын хэрэгцээний үе буюу хүйтний улиралд 10-12 дугаар сар болон дараа оны 1 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд хийнэ. Нүүрс олборлолтын ажлыг зөвхөн зээг давхраас дээр ашиглалтын 905А талбайд явуулна.

##### Хөрс хуулалт

Төлөвлөгөөт жил хөрс хуулалтын ажил хийхгүй.

2022 онд нүүрсний хаягдлыг бууруулах, сум, орон нутгийн жижиг хэрэглэгчдийг чанар сайтай ангилан ялгасан нүүрсээр хангах зорилгоор агуулагч чулуулаг болон нүүрсний давхарга дундын завсрын бохирдуулагч үенцэртэй нүүрнээс гар ялгалт хийж 500 тонн нүүрс хэрэглэгчдэд нийлүүлэн хаягдал бохирдолтын хэмжээг багасгаж байгаа бөгөөд 2023 онд мөн үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

##### Хайгуул өрөмдлөг

2022 онд хөрс хуулалтын ажил явагдахгүй орон нутаг болон Чандмань сумын дулааны хэрэгцээнд зориулан нүүрс олборлон гаргахаар төлөвлөсөн болно. Тиймээс орон нутаг болон сумын дулааны хэрэгцээний нүүрсийг уурхайн авахад бэлэн нүүрсний мөрөгцөгөөс хангана. Хөрс хуулалтын ажил хийгдэхгүй учир тэсэлгээ хийх шаардлагагүй болно.

#### 1.5. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

##### Физик газар зүй


Орд нь Алтайн нурууны зүүн өмнөх талын салбар уулс болох Түгээн, Хар-Аргалантын нуруудын хооронд орших Бигэрийн хотгорт оршино. Орд нь 2300 гаруй метрийн өндөрлөгтэй (далайн түвшнээс дээш) гадаргуу бүхий талбайг эзэлнэ. Чулуун нүүрсний Зээгтийн орд нь Алтай хотоос 250 км, Чандмань сумаас баруун хойш 8 км зайд оршино. Ордод ойр байрлах хилийн боомт нь БНХАУ-д нэвтрэх Говь-Алтай аймгийн Бургастайн боомт 230 км-т, Шивээхүрэнгийн боомт 300-350 км зайтай тус тус оршино. Газарзүйн байршлын солбицол:

ХӨ 42'2'50" – 42'22'50"

ХӨ 97'51'30" – 97'54'30"

Физик газарзүйн мужлалаар уг талбай нь Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн бүсэд багтдаг. Баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон Алтайн салбар уулс болох Гичгэний нурууны ард оршино. Уулс нь гүн сайр, жалгаар хүчтэй хэрчигдсэн байх ба талбайн өмнөд хэсгээр орших уулс нь голчлон эгц хажуутай, шовх оройтой, хойноосоо урагш чиглэлтэй гүн хавцал, жалгаар хүчтэй хэрчигдсэн байдалтай. Түүний заримаар нь авто машин, ердийн хөсгөөр нэвтрэх боломжтой. Талбайн үнэмлэхүй өндөр нь урдаасаа хойшлох тусам өндөрсөх хандлагатай. Үнэмлэхүй өндөр нь дунджаар 2200-2500 м байна.

Зураг №3. Байгалийн бүс бүслүүр ба эко систем.



### БАЙГАЛИЙН БҮС БҮСЛҮҮР БА ЭКОСИСТЕМ



#### Уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилийн дундаж температур -1,8-аас +3,4 °С-т хэлбэлзэнэ. Хүйтний улирал үргэлжлэх хугацаа 6 сар ба түүнээс дээш. Гэхдээ 10-р сараас 4-р сар хүртлэх хасах температуртай байдаг. Өвөл хамгийн багадаа буюу -22,3 °С, дунджаар -31°С байна. Тунадас 150-200 мм, өвөл -31°С дундаж температуртай, зун хамгийн их буюу +30°С орчим байсан гэж тэмдэглэгджээ. Хамгийн халуун үе 7-р сард +26°С дундаж температуртай байна. Зун зарим өндөр уулсынхаа оройгоор цас хайлалгүй жил өнжих нь ч бий. Тунадасны хэмжээ олон жилийн дунджаар 48,6-214,8 мм. Сарын дундаж чийглэг 28-

29%, жилийн дундаж чийглэг 70% байдаг. 4, 5-р сард 25 м/с хүртэл хурдтай хүчтэй шороон шуурга болдог.

### Хөрс

Тусгай зөвшөөрөлтэй ашиглалтын талбайд цайвар хүрэн хөрсний хэв шинж тархах бөгөөд Монгол орны хөрс газарзүйн мужлалаар говийн их мужийн Монголын өрнөд мужийн Бигэр- Баянголын 30-р тойрогт хамрагдана.

Дутуу хөгжилтэй цайвар хүрэн хөрс Тусгай зөвшөөрөлтэй талбайд гүвээ толгодын орой болон ар хажуу хэсгээр ихэвчлэн тархана. Хатуу суурь чулуулгийн элювийн хурдас дээр тогтворжих бөгөөд хэмхдэс сайр чулуу ихтэй байдаг онцлогтой.

Цайвар хүрэн хөрс Тусгай зөвшөөрлийн талбайн дийлэнх хэсгээр тархах бөгөөд гол онцлог нь гадаргын хувьд харьцангуй тэгшивтэр газруудад тархана. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй байдаг учраас салхины үлээгдэлд хялбар өртөж том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байна.

Далд глейрхэг (нугархаг) цайвар хүрэн хөрс Энэ хөрс нь талбайн ухаа толгодын хоорондох хотгор газрыг дагаж тархах бөгөөд үетэн алаг өвст ургамал бүрхэц энд 50-60 хувь хүрнэ. Энэ хөрсөнд орчин тойрны өндөрлөг газраас гадаргын урсцаас ирж хуралдах эс чийгийн нөлөөгөөр улирлын чанартай түр зуурын нэмэгдэл чийг бий болж нугархаг шинж үүсэх нөхцөл бүрддэг байна.

Эртний цэвдгийн үлдмэл шинжтэй хар хүрэн хөрс Энэ хөрс нь тусгай зөвшөөрөлтэй талбайд нүүрсний карьерын орчимд гүдгэрдүү газрын оройгоор багахан хэмжээний талбай эзлэн тархсан байна. Эртний цэвдэгт үзэгдлийн ул мөр болох шаантаг хэлбэртэй, ихэнхдээ карбонатгүй бага зэрэг ялзмагжсан нунтаг шороогоор дүүргэгдсэн. Энэхүү эртний цэвдгийн үлдмэл шинж морфологийн хувьд хадгалагдаж хөрсөн бүрхэвчийг алаг цоог шинжтэй болгож байна.

### Ургамал

Бидний судалгаа явуулсан Зээгтийн нүүрсний уурхайн урд талд Монгол Алтайн нурууны төгсгөл болох Эмээлцэгийн нуруу оршино. Гичгэний нуруу зэрэг уул, нуруудын оргил хэсгээр тархах өндөр уулын хуурай хээрийн жижиг дэгнүүлт үетэн-бушилзат, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-бушилзат түгээмэл тохиолдоно. Эмээлцэгийн нурууны ар хөндийд нам уулсын уулын хээрийн элдэв өвс-хялганат, тэгш тал хөндийд элдэв өвс хялганат, ерхөг-хялганат дунд зэрэг талхлагдсан бүлгэмдэл зонхилон тархана.

Мөн нуурт хонхор, давсархаг газрын ургамалжилт тохиолдлоо. Өндөр уулын хээрийн бүсийн цайвар хүрэн хөрстэй газар *Stipa gobica*, *Stipa glareosa*, *Glesistogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Allium polyrrhizuma* бүлгэмдэл, цав толгодоор чулуусаг алаг өвснөөс бүлгэмдэл үүсэн тархана. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нийт хэмжээнд 17 овог 36 төрөлд хамаарагдах 44 зүйл ургамал бүртгэгдлээ. Овгуудын дотроос үетэн 2 зүйл, нийлмэл цэцэгтэн 8 зүйл, луультаан 6 зүйлтэйгээр бусад овгийн ургамал 1-3 зүйлтэй тохиолдож байна. Түүнчлэн зүйлүүдийн дотроос 3 заримдаг сөөгөнцөр, 13 зүйл нэг наст



ургамал байгаа бөгөөд 28 зүйл олон наст ургамал ургаж байна. Эмийн болон ашигт ургамал 19 зүйл бүх ургамлууд хадлан бэлчээрийн ач холбогдолтой. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамаараад ургамлын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ.

#### Ан амьтан

Чандмань сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтны олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархцын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь уул, асга, хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, ольби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиго, хулан жороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавж болон жижиг далавчтанаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

#### **1.6. Усны хэрэглээ**

Зээгтийн уурхай нь 2022 онд улирлын чанартай 14 хоног ажиллана. Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлт аймгийн байгаль орчны газраар гаргуулна.

Сумын Засаг даргын тамгын газартай ус ашиглах гэрээ байгуулна.

#### Технологийн зориулалтай ус

Орон нутгийн нүүрс олгох ажил хүйтний улиралд явагддаг ба тоосжилт дарах зорилгоор ус ашиглахаар зам талбай хөлдөж өөрөө буулгагч халтирах гулгах, осол аваар гаргах эрсдэл үүсдэг тул технологийн зориулалтаар ус ашиглах боломжгүй байдаг.

#### Ус шүүрүүлэлт

Зээгтийн уурхайн нь одоогоор харьцангуй бага гүнд (25м орчим) ашиглалт явж байгаа учир гүний усны түвшинд хүрээгүй байна. Ордын хэмжээнд гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажил хийгдсэн боловч уурхай ахуйн хэрэглээний усаа сумын төвийн худгаас зөөвөрлөн хэрэглэж байна.

#### Ахуйн хэрэглээний ус

Уурхайн ахуйн хэрэглээний усыг уурхайгаас 9 км-ийн зайд орших Чандмань сумын төвийн худгаас зөөж хэрэглэнэ. Уурхайд орон нутгийн нүүрс олгохоос бусад үед 2 ажилтан, нүүрс олгох үед 7 хүн ажиллах ба нийт 120 тонн ус хэрэглэнэ.

Уурхайн ажилчдын ундны усыг шүүх 4 төрлийн шүүлтүүртэй ба 9, 12 сарын хугацаатай солино.

*Зураг№4. Ундны усны шүүлтүүрийг гал тогооны тосгуурт холбосон байдал.*



## **ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **2.1. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**

#### **2.1.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл**

Цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Агаар орчны бохирдолт:

Хөрс хуулалт

Нүүрс олборлолт

Овоолго

#### Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр хээрийн анги орчим
- Чандмань сум, багийн оршин суугчид
- Амьтан
- Ургамал

#### Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- Агаар дахь тоос болон хорт хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- Тоос 0.5 мг/м<sup>3</sup>
- Нүүрстөрөгчийн дутуу исэл 5.0 мг/м<sup>3</sup>
- Альдегид 0.035-0.5

#### Ажиглалт, хяналт явуулах шаардлага

- Мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц дээж авхуулах, шинжилгээ хийлгэнэ.
- Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвийн эмч нарын үзлэгт бүх ажиллагчдыг хамруулна.
- РМ<sub>2.5-10</sub> тоосжилтын хэмжилт хийх

#### 2.1.2 Хөрсний бохирдолт

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна.

#### Хөрсний бохирдол

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон
- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн
- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

#### Нөлөөлөлд өртөх объект

##### « Шимт хөрс бүхий газар

- Малын бэлчээр
- Амьтан ургамал

#### Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- БОЯ, ЭХБ-ны сайдын 1997 оны 143/А, 352/А тоот тушаалын 2, 3, 5-р хавсралт

#### Ашиглалт явуулах шаардлага

- Газрын төлөв байдал, хөрсний чанарын дээжийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- Уулын ажлыг зөвхөн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

### 2.1.3 Усны бохирдолт

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорх усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Гадаргын ба гүний ус

- Гадаргын ба гүний усанд одоогоор нөлөөлөл багатай

Нөлөөлөлд өртөх объект

- Хүн ба Мал
- Амьтан ургамал

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- БОЯ, ЭМНХЯ-ны сайдын 1997 оны 143/А тоот тушаалын 2, 3, 5-р хавсралт
- Гадаргын усны цэврийн ангилал

Ажиглалт явуулах шаардлага

- Ундны усны хяналт баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

### 2.1.4 Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа, хөрс хуулалт, автомашины хөдөлгөөн зэргээс ургамал талхлагдах доройтох зэрэгцээ тоос, ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож ургамлан бүрхэвч багасах нөлөөлөл үүснэ. Уурхайн үйл ажиллагааны дуу чимээ, автомашины хөдөлгөөн зэргээс шувууд, амьтад уурхайн талбай болон ойр орчмын талбайгаас дайжих нөлөөлөл үүснэ.

Болзошгүй нөлөөллийн эх үүсвэр

- Уулын бэлтгэл ажлууд
- Уурхайн хөрс хуулалт ба карьер
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Олборлолт (нүүрс ачих тээвэрлэх)
- Хаягдал аж ахуйн (нүүрсний хаягдал, хаягдлын гадаад, дотоод овоолго)
- Талбайн гадаргын ус зайлуулах систем
- Шатах тослох материалын агуулах, шатахуун түгээх станц
- Зам, тээвэр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Хүн, машин механизм хөдөлгөөн

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхай орчмын ургамал амьтан

## 2.2. **Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа**

Зээгтийн нүүрсний уурхайн төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчимшлийг

тодруулахын тулд Леопольдын матрицын аргыг ашиглав.

## Хүснэгт 2. Леопольдын матрицын аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ

Төслийн бүрэлдэхүүн	Барилга байгууламж барих үеийн барилгын материалын хаягдал	Химийн бүтээгдэхүүн /будаг, эмульс, шохой, цемент гэх мэт/	Авто тээврийн хэрэгсэл олшрох	Ой, хээрийн түймэр	Хүмүүсийн бөөгнөрөл	Хатуу хог хаягдал	Шингэн хаягдал	Ил задгай гал түлэх	Бүгд
Агаарын бохирдол	+	+	+	+	-	++	+	+	8
Хотгор гүдгэрийн төрх	+	-	+			+	*		3
Гадаргын усны бохирдол	-	++	+	+	++	++	++		11
Газрын доорх усны бохирдол	-	++	+	-	+	++	+++	-	9
Хөрс	++	+++	++	+++	+++	++	++	+	17
Ургамлан бүрхэвч	+	++	++	+++	+++	++	+	++	
Амьтны аймаг	-	+	++	++	+	+	+	+	
Шавж бичил биетэн	+	++	+	++	+	++	+	+	
Усны нөөц	-	+	-	-	-	-	-	-	

Дээрх үнэлгээнээс харахад тус нүүрсний орд нь уурхайн ашиглалтын үеийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хэмжээ их, тэдгээр нь өөр хоорондоо харилцан уялдаатай, нэг нь нөгөөдөө шууд болон дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна. Гэхдээ энэхүү нөлөөллүүд дотор онц уршигтай сөрөг нөлөөлөл байхгүй. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгээс хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч талхлагдаж төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, хүн ам, машин техникийн бөөгнөрөл дуу чимээнээс ан амьтан үргэж дайжих зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болох магадлалтай.

### Гео орчин

Уурхайн малталт, тээвэрлэлт барилга байгууламж барих, угсрах суурьшил болон суваг шуудуу татах, нүх цооног ухах зэрэг газар шорооны бүх ажлаар тарчиг сийрэг, төрөл зүйл цөөн ургамалтай энэ газрын хөрс ургамлан нөмрөг эвдэрнэ. Нуралт, гулсалт, суулт үүсэж болох догол мөрөгцөгүүдтэй уурхайн малталтууд, өвс ургамалгүй элэгдэж талхлагдсан элс шороон зам, талбай бий болно. Мөн хөрс хуулалтын хоцрогдлоос шалтгаалан доод түвшнүүдийн зарим хэсэг дэх хажуугийн налууугийн ерөнхий өнцөг 45° - аас дээш болох тохиолдол гардаг нь гулсалт нуралт болох аюулд хүргэж болзошгүй юм.

### Гадаргын ба газрын доорх ус

Чулуун нүүрсийг ил аргаар олборлох хэвийн нөхцөлийн хангах, нүүрсний чанарыг сайжруулах зорилгоор түүний чийгийг багасгах, олборлолтын явцад уурхайн малталтын хана, ёроолоос шүүрэх хөрсний усыг гадагш насосоор татаж зайлуулна. Энэ нь аажимдаа газрын доорх ус буюу усны нөөцийн түвшинд нөлөөлөх магадлалтай.

### Агаар орчин

Өрөмдлөг, тэсэлгээ, уурхайн малталт, гадаад овоолго, тэвээрэлтийн зам, нүүрс олборлолт бутлалт, тээвэрлэлт, суурьшил хөдөлгөөнөөр элэгдэж, талхлагдсан хөрс газар болон технологийн бүх үйл ажиллагаатай холбогдож агаар орчин бохирдоно.

### Хөрс, ургамал, биологийн төрөл зүйл

Төслийн талбай түүний ойр хавийн хөрс нүүрс олборлолтоор эвдрэх, элэгдэж тархлагдах нь ургамлын аймгийн зүйл төрөл доройтох, ургамлын бүрхэц ядуурах, өсөлт хөгжилт муудаж ургац буурах, шинэ орчинд зохицсон хөл ургамлын зүйл төрөл ургах зэрэг сөрөг нөлөө гарна. Ургамалшилтад нөлөөлөх өөр нэг хүчин зүйл бол орчны хөрсний ус чийгийн дутагдал юм. Хур тунадас багаас орчны чийг хангамж багасах, гүний усны түвшин буурч, гадаргын урсац ширгэж үгүй болох зэргээс хөрсний үржил шим, ус чийг багасна. Энэ нь ургамлын бүрхэц буурах, төрөл зүйл цөөрөх нэг шалтгаан болно.

Нүүрсний ордыг ил аргаар олборлон ашиглах үед уурхайн малталт болон зам талбайд хөрс, ургамлын хамтаар амьтны аймаг ялангуяа шавж хорхой үе нугаламгүй амьтад, шавж идэштэн хийгээд бичил амьтад устаж үгүй болно.

## **2.3. 2022 оны төлөвлөгөөний гол зорилтын биелэлт**

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажилласан.

Тус уурхай нь зөвхөн орон нутгийн хэрэгцээнд зориулж ажиллаж байгаа тул 2022 онд байгаль орчныг хамгаалах зардалд 19,200,000 төгрөг төсөвлөсөн ба хуулийн шаардлага хангаж байгаль орчны зардлын тавин хувь болох 9,600,000 төгрөгийг тайлант хугацаанд БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан.

Мөн Монгол Улсын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгальд ээлтэй орчин үеийн технологи нэвтрүүлэх, байнгын хяналт, мониторинг хийх, олборлолтын бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх замаар байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчны зохистой бодлого барин ажилласан.

## 2.4. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн нүүрс олгох ажлын явцтай давхцуулан хийж гүйцэтгэсэн ба хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил орон нутгийн дулааны хэрэгцээг хангах зорилгоор бага хэмжээний ажил хийсэн.

### 2.4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил

А. Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **1.1-д заасан** “Тээврийн хэрэгслийн яндангаас утаа болон хорт хий ялгарах. Түлшний чанарын хяналт, техникийн үзлэг оношилгоог тогтмол тогтоосон хугацаанд хийж байх” гэсэн ажлын биелэлт:

Зээгтийн нүүрсний уурхайд 2022 оны 10 дугаар сарын сүүлийн 10 хоногт орон нутгийн иргэд, аж ахуй нэгжид нүүрс олгохоос бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2022 оны турш гэрээт харуул хамгаалалтын 1 ажилтан тогтмол харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж ажилласан.


Зээгтийн уурхайд 2022 онд хөрс хуулалтын ажил хийгдээгүй бөгөөд тогтмол уурхайд ашигласан тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл байхгүй. Харин шаардлагатай үед компанийн эзэмшлийн 0489 УНП болон 6181 УБВ гэх тээврийн хэрэгслүүд Зээгтийн нүүрсний уурхайн кемпэд ажилласан бөгөөд эдгээр тээврийн хэрэгслүүдийг жил бүр эрх бүхий байгууллагаас шалгадаг техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулан ажиллаж байна.

Зураг №5. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ
Улсын дугаар: 0489УНП Загвар: Toyota Land Cruiser Үйлдвэрлэсэн он: 2015 Залгах COVID-19 зөвшөөрөл	Үзлэгт орсон огноо: 2022/08/22 Үзлэгт дахин орох огноо: 2023/08/22 Тэнцсэн эсэх: Тийм
Улсын дугаар: 6181УБВ Загвар: Toyota Land Cruiser Үйлдвэрлэсэн он: 2017 Залгах COVID-19 зөвшөөрөл	Үзлэгт орсон огноо: 2022/04/08 Үзлэгт дахин орох огноо: 2023/04/08 Тэнцсэн эсэх: Тийм

Мөн түүнчлэн дээрх хоёр тээврийн хэрэгслийг 1,000 км тутамд авто тээврийн үзлэгт оруулдаг.

Зураг №6. Авто тээврийн хэрэгслийг тогтмол оруулдаг үзлэг, оношилгоо



**ТАВАН БОГД ХХК**

НЭХЭМЖЛЭХ

Огноо: 2022.07.28  
Хүчинтэй хугацаа: 2022.08.04

**НЭХЭМЖЛЭХ**

Огноо: 2022.07.28  
Хүчинтэй хугацаа: 2022.08.04

**НЭХЭМЖЛЭГ**

Таван Богд ХХК  
Сүхбаатар дүүрэг 1-р хороо Нарын зам-53  
Улаанбаатар хот 14230, Мөнхлал Уул  
Утас: 976-7577000  
toyota\_koo@smartcar.mn

**Уламжлалч**

Нэр: Г.Говь-Эрдэнэ Ивандорж ХХК  
Автомашины загвар: LAND CRUISER 200 VX V8  
Арван дугаар: ГТМНУ/051504178999  
Утсын дугаар: 04-89 3111  
Утасны дугаар: 99168797

Харилцах хувьцаа/Beneficiary's Bank: Хаяг байр: Голцогт байр: ХХ банк

Харилцах хувьцаа/Account: 5022297830 1102566920 499003604

Дансны нэр/Account name: Таван Богд ХХК

Регистрийн дугаар: 2074699

№	Сэлбэгийн нэршил	Хэмжээ нэгж	Тоо ширээг	Үнэ		байгуулалт хугацаа
				Нэгж үнэ	Нийт үнэ	
1	Иерун хойд бөмбөлөг татуурга	ширээг	1	444,000T	444,000T	Бэлэн
2	Зүүн хойд бөмбөлөг татуурга	ширээг	1	438,000T	438,000T	Бэлэн
3	Иерун урд ачаа гар	ширээг	1	1,951,000T	1,951,000T	Бэлэн
4	Панел	ширээг	1	19,000T	19,000T	Бэлэн
5	Автомашины хөдөлгөөн	литр	4	50,000T	160,000T	Бэлэн
6	Хүч дамжуулах ангины тос	литр	4	35,000T	144,000T	Бэлэн
7	Хөдөлгөөний агар шүүгч	ширээг	1	203,000T	203,000T	Бэлэн
8	Хөдөлгөөний тос	литр	8.7	27,000T	234,600T	Бэлэн
9	Тосны нүүр	ширээг	1	91,000T	91,000T	Бэлэн
10	Тусгай шүүр	ширээг	1	159,000T	159,000T	Бэлэн
11	Дугаарын гурвалж загвар	ширээг	2	7,000T	14,000T	Бэлэн
12	Их гурвалж загвар	ширээг	1	307,000T	307,000T	Бэлэн
13	Толгой тохиргоо	тохиргоо	1	88,000T	88,000T	Тохиргоо
14	Явах эзэмшлэг: оношилгоо	оношилгоо	1	50,000T	50,000T	оношилгоо
					698,000T	
					<b>Нийт дүн</b>	<b>5,000,000T</b>
					<b>Хөнгөлөлт 35%</b>	<b>1,750,315T</b>
					<b>Нийт дүн</b>	<b>3,250,385T</b>
					<b>Ажиргалбар</b>	<b>800,000T</b>
					<b>Нийт ННД-ийн дүн</b>	<b>4,050,585T</b>

Уламжлалчтай холбоотой мэдээлэл

Төс: Дүн

17. Хөдөлгөөний тос: 444,000T

18. Хөдөлгөөний тос: 438,000T

19. Хөдөлгөөний тос: 1,951,000T

20. Хөдөлгөөний тос: 19,000T

21. Хөдөлгөөний тос: 50,000T

22. Хөдөлгөөний тос: 35,000T

23. Хөдөлгөөний тос: 203,000T

24. Хөдөлгөөний тос: 27,000T

25. Хөдөлгөөний тос: 91,000T

26. Хөдөлгөөний тос: 159,000T

27. Хөдөлгөөний тос: 7,000T


28. Хөдөлгөөний тос: 307,000T

29. Хөдөлгөөний тос: 88,000T

30. Хөдөлгөөний тос: 50,000T

31. Хөдөлгөөний тос: 698,000T

32. Хөдөлгөөний тос: 4,050,585T



**ТАВАН БОГД ХХК**

НЭХЭМЖЛЭХ / ҮНИЙН САНАЛ

Огноо: 2022.07.28  
Хүчинтэй хугацаа: 2022.08.04

**НЭХЭМЖЛЭХ / ҮНИЙН САНАЛ**

Огноо: 2022.07.28  
Хүчинтэй хугацаа: 2022.08.04

**НЭХЭМЖЛЭГ**

Таван Богд ХХК  
Сүхбаатар дүүрэг 1-р хороо Нарын зам-53  
Улаанбаатар хот 14230, Мөнхлал Уул  
Утас: 976-7577000  
toyota\_koo@smartcar.mn

**Уламжлалч**

Нэр: Г.Говь-Эрдэнэ Ивандорж ХХК  
Автомашины загвар: LAND CRUISER 200 VX V8  
Арван дугаар: ГТМНУ/051504178999  
Утсын дугаар: 04-89 3111  
Утасны дугаар: 99168797

Харилцах хувьцаа/Beneficiary's Bank: Хаяг байр: Голцогт байр: ХХ банк

Харилцах хувьцаа/Account: 5022297830 1102566920 499003604

Дансны нэр/Account name: Таван Богд ХХК

Регистрийн дугаар: 2074699

№	Сэлбэгийн нэршил	Хэмжээ нэгж	Тоо ширээг	Үнэ		байгуулалт хугацаа
				Нэгж үнэ	Нийт үнэ	
1	Иерун хойд бөмбөлөг татуурга	ширээг	1	444,000T	444,000T	Бэлэн
2	Зүүн хойд бөмбөлөг татуурга	ширээг	1	438,000T	438,000T	Бэлэн
3	Иерун урд ачаа гар	ширээг	1	1,951,000T	1,951,000T	Бэлэн
4	Панел	ширээг	1	19,000T	19,000T	Бэлэн
5	Автомашины хөдөлгөөн	литр	4	50,000T	160,000T	Бэлэн
6	Хүч дамжуулах ангины тос	литр	4	35,000T	144,000T	Бэлэн
7	Хөдөлгөөний агар шүүгч	ширээг	1	203,000T	203,000T	Бэлэн
8	Хөдөлгөөний тос	литр	8.7	27,000T	234,600T	Бэлэн
9	Тосны нүүр	ширээг	1	91,000T	91,000T	Бэлэн
10	Тусгай шүүр	ширээг	1	159,000T	159,000T	Бэлэн
11	Дугаарын гурвалж загвар	ширээг	2	7,000T	14,000T	Бэлэн
12	Их гурвалж загвар	ширээг	1	307,000T	307,000T	Бэлэн
13	Толгой тохиргоо	тохиргоо	1	88,000T	88,000T	Тохиргоо
14	Явах эзэмшлэг: оношилгоо	оношилгоо	1	50,000T	50,000T	оношилгоо
					698,000T	
					<b>Нийт дүн</b>	<b>5,000,000T</b>
					<b>Хөнгөлөлт 35%</b>	<b>1,750,315T</b>
					<b>Нийт дүн</b>	<b>3,250,385T</b>
					<b>Ажиргалбар</b>	<b>800,000T</b>
					<b>Нийт ННД-ийн дүн</b>	<b>4,050,585T</b>

Уламжлалчтай холбоотой мэдээлэл

Төс: Дүн

17. Хөдөлгөөний тос: 444,000T

18. Хөдөлгөөний тос: 438,000T

19. Хөдөлгөөний тос: 1,951,000T

20. Хөдөлгөөний тос: 19,000T

21. Хөдөлгөөний тос: 50,000T

22. Хөдөлгөөний тос: 35,000T

23. Хөдөлгөөний тос: 203,000T

24. Хөдөлгөөний тос: 27,000T

25. Хөдөлгөөний тос: 91,000T

26. Хөдөлгөөний тос: 159,000T

27. Хөдөлгөөний тос: 7,000T

28. Хөдөлгөөний тос: 307,000T

29. Хөдөлгөөний тос: 88,000T

30. Хөдөлгөөний тос: 50,000T

31. Хөдөлгөөний тос: 698,000T

32. Хөдөлгөөний тос: 4,050,585T


Харин орон нутгийн иргэд, аж ахуй нэгжийг өвлийн улиралд нүүрсээр хангах 10 хоногийн хугацаанд оператораар ажилласан компанитай 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээний 11 дүгээр зүйлийн 11.1.7-д “Энэ Гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай Хавсралт №01-т заасан тоо, үзүүлэлт бүхий машин механизм, техник тоног, төхөөрөмжөөр бүрэн хангагдсан ... байна. Гүйцэтгэгч нь техникийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй” гэсэн шаардлагыг тавьж ажилласан бөгөөд тус компани нь Говь-Алтай аймгийн компани учир үзлэг оношилгоо, засвар үйлчилгээгээ уурхайд ирэхээс өмнө гүйцэтгэсэн.



Б. Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **1.2-т заасан** “Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэрсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх. Тоосны дээдэлтийг бууруулах зорилгоор төслийн үйл ажиллагааны туршид зам усалгааг тогтмол хийх” гэсэн ажлын биелэлт:

Зээгтийн уурхайд 2022 оны 10 дугаар сард 10 орчим хоногийн хугацаанд орон нутгийн иргэд, аж ахуй нэгжид өвлийн улиралд дулаанаар хангах зорилгоор нүүрс олголт явагдсан бөгөөд хөрс хуулалтын ажил хийгдээгүй болно. Тиймээс технологийн зориулалтаар ус ашиглаагүй.

Уурхайн олборлолтын замд хурдны хязгаар тогтоосон замын тэмдэглэгээ байршуулж олборлолтын үед тээвэрлэлт хийх өөрөө буулгагч тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний хурдыг хязгаарлан дугуйны эргэлтээс үүсэх тоосжилтыг бага байхаар тооцож хяналт тавин ажилласан.



Зураг №7. Усны ашиглах талаар албан бичиг

Зураг №8. Тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



В. Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **1.3-т заасан** “Төслийн үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх. Агаарын чанар мониторингийн хэмжилт судалгаа хийж гүйцэтгэх” гэсэн ажлын биелэлт:

Мөн 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр уурхайн орчим газраас Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газраар агаарын чанарын шинжилгээ хийлгэхэд агаарын чанарын хяналт шинжилгээний түгээмэл тархалттай бохирдуулагч бодис болох хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/, азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийн явцыг MM84585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй гэсэн дүгнэлт гарсан.

УС,ЦАГ УУР,ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар :2022/04  
Захиалагч : "СЭЖЕР РЕСОРСУС МОНГОЛИА" -ХХК  
Дээжийн тодорхойлолт : Чандмань сум 5-р баг  
Дээж авсан газар : Уурхайн технологийн замын хажуу талаас  
Дээж авсан огноо :2022.12.06  
Дээж авсан хүний нэр, албан тушаал : / Ц.Болормаа /БОШЛ-ийн инженер/  
Шинжилсэн огноо :2022.12.10  
Хуудасны тоо :1/1

➤ Шинжилгээ хийсэн үзүүлэлт-Үр дүн:

№	Тодорхойлсон Элемент	Хэмжих нэгж	Шинжилгээний дүн
1	Чийг	-	1.01
2	РН	mS/cm	8.21
3	P <sub>2</sub> O <sub>5</sub>	мг/кг	16.9
4	NH <sub>4</sub>	мг/кг	39.1
5	NO <sub>3</sub>	мг/кг	20.7
6	Ялзмаг	%	0.15

УЦУОШТ-ийн дарга..... Н.Алтантуяа

Хянасан :

ЦУОТХэлтсийн дарга..... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер ..... Ц.Болормаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Шинжилгээний дүн - тухайн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

УС,ЦАГ УУР,ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар :2022/04  
Захиалагч :“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА”-ХХК  
Дээжийн тодорхойлолт : Чандмань сум 5-р баг  
Дээж авсан газар :Кемпийн хашаан дотроос  
Дээж авсан огноо :2022.12.06  
Дээж авсан хүний нэр, албан тушаал :Ц.Болормаа /БОШЛ-ийн инженер/  
Шинжилсэн огноо :2022.12.10  
Хуудасны тоо :1/1

➤ Шинжилгээ хийсэн үзүүлэлт-Үр дүн:

№	Тодорхойлсон Элемент	Хэмжих нэгж	Шинжилгээний дүн
1	Чийг	-	1.01
2	РН	mS/cm	8.35
3	P <sub>2</sub> O <sub>5</sub>	мг/кг	56.5
4	NH <sub>4</sub>	мг/кг	76.62
5	NO <sub>3</sub>	мг/кг	26.1
6	Ялзмаг	%	0.15

УЦУОШТ-ийн дарга.......... Н.Алтантуяа

Хянасан

ЦУОТХэлтсийн дарга.......... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер .....Ц.Болормаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Шинжилгээний дүн - тухайн шинжилсэн сорьцонд хүчинтэй.


**УС,ЦАГ УУР,ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ**

**ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Дугаар	:2022/04
Захиалагч	:“СЭЖЕР РЕСОРСУС МОНГОЛИА” -ХХК
Дээжийн тодорхойлолт	: Чандмань сум 5-р баг
Дээж авсан газар	: Шимт хөрсний овоолго
Дээж авсан огноо	:2022.12.06
Дээж авсан хүний нэр, албан тушаал	:Ц.Болормаа /БОШЛ-ийн инженер/
Шинжилсэн огноо	:2022.12.10
Хуудасны тоо	:1/1

➤ **Шинжилгээ хийсэн үзүүлэлт-Үр дүн:**

№	Тодорхойлсон Элемент	Хэмжих нэгж	Шинжилгээний дүн
1	Чийг	-	1.02
2	РН	mS/cm	8.16
3	P <sub>2</sub> O <sub>5</sub>	мг/кг	15.7
4	NH <sub>4</sub>	мг/кг	20.9
5	NO <sub>3</sub>	мг/кг	34
6	Ялзмаг	%	0.06

УЦУОШТ-ийн дарга.......... Н.Алтантуяа

Хянасан:

ЦУОТХэлтсийн дарга.......... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер .....




.....Ц.Болормаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Шинжилгээний дүн - тухайн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

### БОШЛабораторийн агаарын шинжилгээний дүн

Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШ Төвийн БОШЛ  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа  
 Дээжийн тоо, төрөл : 1. агаар  
 Хүлээн авсан огноо : 2022.12.06  
 Дээжийн тодорхойлолт : "СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА"  
 /кемпийн хашаан дотроос/  
 Шинжилсэн огноо : 2022.12.10  
 Хуудасны тоо : 1/1

	Өдөр	Цаг	Температур, °C	салхи зүг, градус	хурд, м/с	Чийг, %	Цаг агаарын байдал	Их хурд, м/с
Кемпийн хашаан дотроос	2022.12.06	8	-14,6	ББХ	3	71	үзэгдэлгүй	5
		14	-7,2	Б	6	41	үзэгдэлгүй	3
		20	-11,8	ӨЗӨ	3	59	үзэгдэлгүй	2



Агаарын чанарын үндсэн үзүүлэлт болох Азотын давхар исэл (NO<sub>2</sub>), Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), нь MNS4585:2016 стандартаас давж бохирдоогүй байна.

УЦУОШТ-ийн дарга..... Н.Алтантуяа

Хянагч:

ЦУОТХэлтсийн дарга..... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер..... Ц.Болормаа


Шинжилгээний дүн нь зөвхөн тухайн шинжилсэн дээжэнд хүчинтэй

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

### БОШЛабораторийн агаарын шинжилгээний дүн

Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШ Төвийн БОШЛ  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа  
 Дээжийн тоо, төрөл : 1 агаар  
 Хүлээн авсан огноо : 2022.12.06  
 Дээжийн тодорхойлолт : "СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА"  
 / Шимт хөрсний овоолго /  
 Шинжилсэн огноо : 2022.12.10  
 Хуудасны тоо : 1/1

	Өдөр	Цаг	Температур, °C	салхи зүг, градус	хурд, м/с	Чийг, %	Цаг агаарын байдал	Их хурд, м/с
Шимт хөрсний овоолго	2022.12.06	8	-14,6	БХ	3	71	үзэгдэлгүй	5
		14	-7,2	Б	2	41	үзэгдэлгүй	3
		20	-11,8	ӨЗӨ	2	59	үзэгдэлгүй	2



Агаарын чанарын үндсэн үзүүлэлт болох Азотын давхар исэл (NO<sub>2</sub>) , Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) , нь MNS4585:2016 стандартаас давж бохирдоогүй байна.

УЦУОШТ-ийн дарга..... Н.Алтантуяа

Хянасан :

ЦУОТХэлтсийн дарга..... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер..... Ц.Болормаа

Шинжилгээний дүн нь зөвхөн тухайн шинжлэсэн дээжинд хүчинтэй

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

**БОШЛАБОРАТОРИЙН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Дугаар он/№ : 2022/4  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШТ-ийн БОШЛ  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа  
 Дээжийн тоо, төрөл : 1 ус  
 Хүлээн авсан огноо : 2022.12.06  
 Дээжийн тодорхойлолт : "СЭЖЕР РЕСОРСХС МОНГОЛИА ХХК" Бүлгийн ус/  
 Шинжилсэн огноо : 2022.12.10  
 Үр дүн

Сорьцын нэр /Чандмань сум/ MNS900:2005	Он,сая р,өдөр	рН	Ес	ж/б		БХХ <sub>с</sub>		ПНЧ	NH <sub>4</sub>	NO <sub>3</sub>	NO <sub>2</sub>	P	F	Ca	Mg	Na +K	SO <sub>4</sub>	Cl <sub>2</sub>	HCO <sub>3</sub>	Эрд	Хат	Fe
				мг/л	мг/л	мг/л	мг/л															
	2022-12-06	7.39	390	4.2	-	-	2.1	0.05	0.06	0.001	0.015	0.10	24.4	2.7	33	51.3	8.2	97.6	220.7	1.44	0.18	
		6.5-8.5	-	-	3.0	10.0	1.5	50	1	3.5	0.7-1.5	100	30	-	500	350	-	-	-	7	0.3	

Баталгаажуулсан:

УЦУОШТ-ийн дарга *Н.Алтангуяа*

Хянасан:

ЦУОТХэлтсийн дарга *Т.Дэлгэрмаа*

Шинжилгээг үндэслэсэн:

БОШЛ-ийн инженер *Ц.Болормаа*

Шинжилгээний дүн нь ямар ч үедийн шинжилсэн дээжид хүчинтэй.

Хууль ёсны хяналтын хөрөнгө.

**БОШЛабораторийн тоос, тоосонцорын шинжилгээний дүн**

Дугаар он/№ : 2022/4  
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШТөвийн БОШЛ  
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа  
Дээжийн тоо, төрөл : 1, Тоос  
Хүлээн авсан огноо : 2022.12.06  
Дээжийн тодорхойлох : “СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА”ХХК  
/ Шимт хөрсний овоолго/  
Шинжилсэн огноо : 2022.12.10  
Хуудасны тоо : 1/1  
Үр дүн

Агаар бохирдуулагч бодис	PM10 <sup>3</sup> мг/м <sup>3</sup>
Дундаж	0.078
Их	0.090
Бага	0.022
<b>Хүлцэх хэмжээ</b>	<b>0.100</b>

Баталгаажуулсан:

УЦУОШТ-ийн дарга..... Н.Алтантуяа

Хянасан :

ЦУОТХэлтсийн дарга..... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер .....Ц.Болормаа

Шинжилгээний дүн нь зөвхөн тухайн шинжилсэн дээжэнд хүчинтэй.

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.




**БОШЛабораторийн тоос, тоосонцорын шинжилгээний дүн**


Дугаар он/№ : 2022/4  
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШТөвийн БОШЛ  
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер  
Дээжийн тоо, төрөл : 1, Тоос  
Хүлээн авсан огноо : 2022.12.06  
Дээжийн тодорхойлох : "СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА"ХХК  
/ Шимт хөрсний овоолго/  
Шинжилсэн огноо : 2022.12.10  
Хуудасны тоо : 1/1  
Үр дүн

Агаар бохирдуулагч бодис	PM-2.5 $\text{мг/м}^3$
Дундаж	0.055
Их	0.090
Бага	0.022
<b>Хүлцэх хэмжээ</b>	<b>0.50</b>

Баталгаажуулсан:

УЦУОШТ-ийн дарга.......... Н.Алтантуяа

Хялгасан:

ЦУОТХэлтсийн дарга.......... Т.Дэлгэрмаа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн инженер .....Ц.Болормаа

Шинжилгээний дүн нь зөвхөн тухайн шинжилсэн дээжэнд хүчинтэй.


Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

2.4.2. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил

А. Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **2.1-т заасан** “Уурхайн ус шүүрүүлэлт, усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх. Усны лавлагаа, усны дүгнэлт гаргуулах” гэсэн ажлын биелэлт:

Технологийн зориулалттай ус: Зээгтийн уурхайд 2022 оны 10 дугаар сард 10 орчим хоногийн хугацаанд нүүрс олголт явагдах бөгөөд хөрс хуулалтын ажил хийгдээгүй болно. Тиймээс технологийн зориулалтаар ус ашиглаагүй болно.

Ус шүүрүүлэлт Зээгтийн уурхай нь харьцангуй бага гүнд буюу 25 м гүнд ашиглалт явагдаж байгаа учир гүний усны түвшинд хүрээгүй байна. Ордод гидрогеологийн нарийвчилсан хайгуулын ажил хийгдсэн боловч уурхай ахуйн хэрэглээний усаа сумын төвийн худгаас зөөвөрлөн хэрэглэж байна.



Зураг №10. Ус ашиглах талаар албан бичиг

Б. Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **2.2-т заасан** “Уурхайн ус шүүрүүлэлт, усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх. Усны гэрээ байгуулах” гэсэн ажлын биелэлт:

Ахуйн хэрэглээний ус. Зээгтийн нүүрсний уурхайд 2022 онд 1 харуулын ажилтан ажиллаж байгаа бөгөөд зөвхөн нүүрс олборлож гаргах хугацаанд 14 хүн ажиллаж унд ахуйн хэрэглээний усыг Говь-Алтай аймгийн Чандмань сумын төвийн худгаас тээвэрлэн

хэрэглэсэн.

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын тамгын газартай 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр 01 тоот Ус ашиглах гэрээ байгуулсан бөгөөд энэ Гэрээний дагуу унд ахуйн хэрэгцээнд 10,000 литр унд ахуйн хэрэгцээний усны төлбөр 300,000 төгрөгийг төлсөн.

В. Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **2.3-т заасан** “Уурхайн ус шүүрүүлэлт, усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх. Усны чанар, нөөцийн мониторинг хийх” гэсэн ажлын биелэлт:

Баянхонгор аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний газрын лабораторид унд ахуйн усны шинжилгээ хийлгэхэд Пермагнатын исэлдэх чанар илрээгүй, жинлэгдэх бодис MNS 4943:2015 стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлж болох бохир усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ давсан үзүүлэлт байхгүй байна гэсэн хариу гарсан байна.

#### 2.4.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил

Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **3.1-т заасан** “Шимт хөрсийг стандартын шаардлагын дагуу хадгалж хамгаалах” гэсэн ажлын биелэлт:

Зээгтийн нүүрсний уурхайн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 2019 онд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэсэн.

Энэ жилийн тухайд 2022 оны 10 дугаар сарын сүүлээр бага хэмжээний нүүрс олборлон орон нутгийн дулааны хэрэгцээг хангар зорилгоор 10 орчим хоногийн хугацаатай ажилласан ба хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хөрсний овоолгоос дээж авч шинжүүлэхэд /MNS3310:1991, MNS ISO 10390:2001, MNS6824:2020, MNS ISO 11466:2007/ стандартад заасан үзүүлэлтээс хэтрээгүй, хүлцэх хэмжээнд байгаа нь тогтоогдсон ба бохирдол үүсээгүй байна.

#### 2.4.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдсэн ажил

Байгаль орчны 2022 оны менежментийн төлөвлөгөөний **4.1-т заасан** “Уурхайн үйл ажиллагаанд ухагдах, дарагдах, талбайн бүх ургамлан бүрхэвч устгах. Хүнд даацын машин техник болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх” гэсэн ажлын биелэлт:

Уурхайн олборлолтын замд хурдны хязгаар тогтоосон замын тэмдэглэгээ байршуулж олборлолтын үед тээвэрлэлт хийх өөрөө буулгагч тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний хурдыг хязгаарлан дугуйны эргэлтээс үүсэх тоосжилтыг бага байхаар тооцож хяналт тавин ажилласан.

Зээгтийн нүүрсний уурхайд 2022 оны 10 дугаар сард 10 хоног орон нутгийн иргэд, аж ахуй нэгжид нүүрс олгоход авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг гаргасан зам

буюу маршрутаар явуулж, олон салаа зам гаргаагүй.



*Зураг №13. Зээгтийн уурхайн замын мэдээлэл*


#### **ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Зээгтийн нүүрсний уурхайд 2022 онд зөвхөн орон нутгийн иргэдийг хангах зорилгоор бага хэмжээний нүүрс олборлолтын ажил хийгдэж байгаа бөгөөд энэ уурхайн Техник-эдийн засгийн үндэслэлд заасны дагуу нөхөн сэргээлтийн ажил хийгдэж эхлэх болоогүй байна.

#### **ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

"Сэкер Ресорсус Монголиа" ХХК нь 2022 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 1.5 га газарт 2,500 ширхэг хайлаас мод тарьсан бөгөөд дараах зардлыг гаргасан.

Зураг №14. Мод тарьсан талбайн хэмжээг дор дурдсан зургийн мэдээллээс авна.



Зураг 15. Дүйцүүлэн хамгаалах ажил



№	Зардлын утга	Зардлын дүн (төгрөг)
1.	Модны суулгац -2,500 ширхэг	6,250,000
2.	Мод хамгаалах хашааны материал	4,875,000
3.	Модны суулгац зөөх зардал	96,454.54
4.	Мод услах помпны шатахуун 2022 оны 08, 09 дүгээр сард	500,000
5.	Мод услах помп худалдаж авсан	1,999,800
6.	Мод услах шланк	79,200
<b>Нийт</b>		<b>13,800,454.54</b>

Зураг 16. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд худалдан авсан материал

**НХМаягт Т-1** Сангийн сайрын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**НЭХЭМЖЛЭХ № .....**

Нэхэмжлэгч: Энхцашаа Хариуцагч: Товч Кочил  
 Байгууллагын нэр: Энхцашаа Байгууллагын нэр: Энхцашаа ХХК  
 РД: 5581591 РД: 2862468  
 Хаяг: БЗД 21-р хороо Хаяг: \_\_\_\_\_

Утас: Факс: 80585858  
 Э шуудан: 99090607 Гэрээний № \_\_\_\_\_  
 Банкны нэр: Хаан Нэхэмжилсэн огноо: 2022.05.10  
 Банкны дансны дугаар: 5431486957 Гөлбөр хийх хугацаа: \_\_\_\_\_

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хашаас	5000	2,500	12,500,000
				\$
				Дүн <u>12,500,000</u>
				НӨАТ <u>12,500,000</u>
				Нийт дүн <u>12,500,000</u>

Мөнгөний дүн Арван хоёр сая таван зуун мянган болно.  
 (Тамга) Захирал: Кочил  
 Нягтлан бодогч: \_\_\_\_\_

**НХМаягт БМ-3** Сангийн сайрын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**УТАС - 99-780957**

**ЗАРЛАГЫН БАРИМТ № .....**

Голын-Ордын ХХК (байгууллагын нэр) Голд Кооп Дорнод ХХК (худалдан авагчийн нэр)  
 Регистрийн № \_\_\_\_\_ Регистрийн № \_\_\_\_\_

2022 он 5 сар 10 өдөр (тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэм-жиг нэгж	Худалдах		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Энхцашаа		14	450000	6,300,000	
2	Энхцашаа		34	150000	5,100,000	
3	Энхцашаа		14	50000	7,000,000	
4	Энхцашаа		20	12000	2,400,000	
5	Энхцашаа		64	15000	960,000	
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						

Дүн 9750000  
 НӨАТ 10725000  
 Нийт дүн 10725000

Хүлээлгэн авсан эд хариуцагч: \_\_\_\_\_  
 Хүлээн авагч: \_\_\_\_\_  
 Шалгасан нягтлан бодогч: \_\_\_\_\_

**ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Зээгтийн нүүрсний уурхайн 905А, 11965А, 12417А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбай болон нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор айл эрх байхгүй болно. Иймээс 2022 онд энэ талаар ажил хийгдээгүй.

**ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах,

бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилгоор манай компани хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэнтэй хамтарч археологийн хайгуул судалгаа, археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2011-2012 онуудад амжилттай хэрэгжүүлж дууссан.

### **Археологийн хайгуул судалгааны ажил-2011 он.**

Судалгааны ажлын товч үр дүн: Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг Зээгтийн нүүрсний уурхай орчим буюу тус компанийн А8273, А905, А11965, А14217 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 2011 оны 04 дүгээр сарын 13-наас мөн оны 04 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл нийт 9 хоног археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг ШУА-Археологийн Хүрээлэнгийн баг хийж гүйцэтгэсэн.

Хээрийн судалгааны ажилд тус хүрээлэнгийн Авран хамгаалах археологийн судалгааны секторын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, тус хүрээлэнгийн Соёлын өвийг хариуцсан захирлын зөвлөх, доктор, профессор Б.Гүнчинсүрэн, эрдэм шинжилгээний ажилтан, докторант Б.Эрдэнэ, магистрант Б.Батдалай нар оролцон ажиллав. Байрлал зүй болон гадаад зохион байгуулалтаас харахад дундад зууны үед холбогдох булш, чулуун байгууламж байх боломжтой юм.

### **Зээгтийн нүүрсний уурхай орчимд хийсэн хайгуул судалгааны ажлын товч үр дүн**

#### **Хүснэгт №4**

<b>№</b>	<b>Дурсгалын дугаар</b>	<b>Төрөл</b>	<b>Солбилцол</b>	<b>Тайлбар</b>
1.	Зээгт-1	Булш	N45 21 18.8 E97 54 45.1	Хөшөө чулуутай зууван дугуй булш
2.	Зээгт-2	Булш	N45 21 19.0 E97 54 45.3	Зууван дугуй булш

### **Археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажил-2012 он.**

Малтлага судалгааны ажлыг 2012 оны 4 дүгээр сарын 30-наас мөн он ы5 дугаар сарын 03-ны хооронд нийт 4 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Малтлага судалгаанд хамрагдсан дээрх хоёр дурсгал нь Чандмань сумын төвөөс баруун тийш 8 км, Зээгтийн нүүрсний уурхайн хээрийн отогоос зүүн урд зүгт 2 км зайд дэнжийн баруун талын налуу энгэрт зэрэгцэн оршино. Дурсгалын гадаад дараасны хэлбэрийн хувьд зууван дугуй хэлбэрийн 570 x 300 см, 240 x 320 см хэмжээтэй сийрэг чулуун дараастай байсан бөгөөд малтлагын явцад ямар нэгэн эд өлгийн зүйл, оршуулга болон тахилгын шинж тэмдэг илрээгүй болно. Энэ нь гадаад дотоод байгууламжийн зарим шинж тэмдгээрээ чулуун овоолгот булштай ижил боловч оршуулга үйлдсэн ул мөр байхгүй “хоосон булш” буюу кенотаф байж болох талтай байна.



## ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой. Химийн бодис үйл ажиллагааны хүрээнд ашиглагдахгүй.

Хийгдсэн ажил:

- “Зээгтийн уурхайн 2022 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г нийт ажилтнуудад сургалтаар орж танилцуулсан;

*Зураг 17. Сургалтын үеийн зураг*



- Нийт ажилтнуудад ХАБЭА-н сургалт орж, шалгалт авч аюулгүй ажиллагааны мэдлэг олгосон;

*Зураг 18. Сургалтын үеийн зураг*



- Тоног төхөөрөмж ажиллуулах үед мөрдөх

аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулсан.

Зураг 19. Зааварчилгааны үеийн зураг



- Өдөр тутам ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулж ажилласан (Гэрээт байгууллагын ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хамруулсан байх).

Зураг 21. Өдөр тутмын зааварчилгааны үеийн зураг



№	Овоо аяр	Амжилт, өдөр	Ор. сар, жил	Хайртай ажил	Хөвсгөрөө ажилтан байх, зураг ажил хариуцаж байх, өдөр тутам	Замнахын үеийн үүрэг	Замнахын үеийн үүрэг
1	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	1	Монгол
2	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	2	Монгол
3	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	3	Монгол
4	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	4	Монгол
5	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	5	Монгол
6	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	6	Монгол
7	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	7	Монгол
8	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	8	Монгол
9	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	9	Монгол
10	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	10	Монгол
11	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	11	Монгол
12	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	12	Монгол
13	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	13	Монгол
14	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	14	Монгол
15	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	15	Монгол
16	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	16	Монгол
17	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	17	Монгол
18	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	18	Монгол
19	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	19	Монгол
20	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	20	Монгол
21	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	21	Монгол
22	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	22	Монгол
23	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	23	Монгол
24	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	24	Монгол
25	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	25	Монгол
26	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	26	Монгол
27	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	27	Монгол
28	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	28	Монгол
29	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	29	Монгол
30	В.Бондолов	02-24	2022.11.9	Ажлын үүрэг	ХАБЭА-н үүрэг	30	Монгол

- Уурхайн талбайн гүйцэтгэгч байгууллагын ХАБЭА хариуцсан инженер, Уурхайн инженер хяналт тавьж осол, эрсдэлээс урьдчилсан сэргийлж ажилласан.

*Зураг 20. Гүйцэтгэгч компанийн ажилтнуудад осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх анхан шатны зааварчилгаа, давтан зааварчилгаа өгч, тайлбайн хяналт хийж байгаа зураг*



- Уурхайд галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүрз, жотуу, галын хор гэх зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан.

*Зураг 21. Галын хор, аюулгүй байдлыг хангах чиглэлийн уурхайд ажилласан байдал*



осол аваарын орчныг “бүх зүйл хэвийн” гэсэн заавар өгөх хүртэл хяналтдаа байлгасан.

Ноцтой осол, онцгой байдлын менежментэд оролцох хэн боловч өөрсдийн үүрэг хариуцлага болон аваар устгах үйлдлүүдийг Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хариуцах ба энэ талын давтан сургалтыг жил болгон зохион байгуулж байх болно.

- Дэмжлэг үзүүлэх хүн хүч

Уурхайн талбай дээр дараах дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн бэлэн байх ёстой. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженер

Чандмань суман дээр доорх бүрэлдэхүүн бэлэн байна:

- Орон нутгийн эмнэлэг (эмч, сувилагч) Холбоо барих хаягийг Хавсралт В
- Цагдаагийн 3 ажилтан: Хэсгийн төлөөлөгч, Цагдаа, олон нийтийн цагдаа
- Улаанбаатараас авах дэмжлэг, тусламж

Дараах төрлийн тусламж, дэмжлэгүүдийг Улаанбаатараас авч болох боловч цаг хугацаа алдах магадлалтай:

- Улаанбаатар дахь “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн төв байрнаас тусламж авах болон мэдээлэл дамжуулах шаардлага гарч болно.
- Компанийн төв байртай Хавсралт А-аар холбоо барина.
- Уурхайн дарга эсвэл түүнийг орлож байгаа хүн уурхайн нөхцөл байдал хүндэрсэн үед Компанийн төв байртай холбогдон зөвлөгөө, зааварчилгаа, тусламж авна.
- Уурхай дээрх харилцаа, холбоо

Системийн тайлбар

Байрлалуудын хооронд радио станц, суурин утас, үүрэн холбоо болон сансрын холбооны тусламжтайгаар ослын үеийн харилцаа холбоог гүйцэтгэх боломжтой. Уурхайн кемп дээр холбоо барих үндсэн аргууд нь:

- Радио холбоог СРМ-ийн уулын хэсэг, засвар болон оффисын бүх автомашин, тоног төхөөрөмжүүдэд суурин хэлбэрээр байрлуулсан байгаа. Радио холбооны хамрах хүрээ нь уурхайгаас 50 км-ийн радиус бүхий газарт байна.
- Үүрэн холбоогоор Улаанбаатартай холбоо барьж болно.

Зээгтийн уурхайн Хяналтын төв нь уурхайн захиргааны байранд байрлана. Энэ байрлалд уурхайгаас гадагш холбоо барих бүх холбооны хэрэгслүүд байна (суурин радио станц, суурин утас болон сансрын холбооны утас). Хамгийн анхны осол болон онцгой байдлын дуудлагыг харуул хамгаалалтын албаны өрөөний диспетчер хүлээн аваад тэндээс холбогдох СРТ-ийн удирдлагад дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Уурхайн ослын удирдлагын төв, кемпийн хурлын танхимд байрлах боломжгүй болсон тохиолдолд (барилга галд өртөх, газар хөдлөлт болох г.м) нөөц байрыг ангийн 5 ханат гэрт байрлуулна. Ослын Хяналтын төв болон нөөц байруудад суурин радио станц (бүх сувгуудыг хүлээн авах/гарах) байрлуулсан байна.

## **Явуулын Холбоо**

Нэг байрлалаас нөгөө байрлалд шилжиж байгаа уурхайн бүсэд байгаа тээврийн хэрэгслүүд машин дотор байрлуулсан радио станцаар холбоо барина. Зарим газарт гар станц болон сүлжээтэй газруудад үүрэн холбоогоор холбоо тогтооно. Шаардлага гарсан тохиолдолд сансрын холбоог алслагдсан газруудад хэрэглэнэ.

Орон нутгийн газар нутгаар явж байх үед тухайн хэлтсийн ажилтнууд “Аяллын журам” даган уурхайн дарга эсвэл түүнийг орлож байгаа хүнээс зөвшөөрөл авсан байна. Аюулгүй ажиллагааны ажилтан аяллын зааварчилгааг өгнө.

## **ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ**

### **Онцгой байдлын үед**

Төр, засгийн байгууллагууд, уурхайн бус эмнэлгийн тусламж үзүүлэгчид, гаднын экспертүүд, байгууллагууд болон бусад олон нийттэй харилцах үүргийг уурхайн дарга эсвэл түүнийг орлож буй хүн хүлээнэ. Уурхайн дарга нь шаардлагатай гаднын нөөцүүдийг тодорхойлж холбоо тогтоохдоо байгууллагын ерөнхий захирал болон Үйл ажиллагаа хариуцсан захиралд мэдээллийг өгч Төрийн байгууллагын тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлж шийдвэр гаргаж харилцаа холбоо тогтоож ажиллана.

### **Ослын дараа**

Осол болсны дараа болон бүх зүйл хяналтад орсны дараа эсвэл онцгой нөхцөл байдал намжсаны дараа хэвлэл мэдээллийнхэн болон олон нийтийн сонирхогч бүлгүүдтэй харилцах бүх харилцаа нь Ерөнхий захирал болон болон түүнийг орлож байгаа хүний зөвшөөрлөөр явагдана.

Ослын шинжилгээг боломжтой гэж үзсэн үед аль болох цаг хугацаа алдахгүй хийх ба шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах боломжтой байна. Осол гарахаас урьдчилан сэргийлэх арга боловсруулах, гарсан ослын шалтгааныг тогтоох зорилготой байна.

## **АВААР УСТГАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

### **➤ ЗЭЭГТИЙН Уурхай-Аваар Устгах Тойм**

Тусгайлан авч үзэх, танигдсан авааруудын төрлүүдийг дараах хуудаснуудад тодорхойлов. Эдгээр ослын төрлүүдийн жагсаалт нь үүгээр хязгаарлагдахгүй боловч тодорхой нөхцөл байдлуудад урьдчилан таамаглах боломжтой гэж тодорхойлсон болно.

Бүх төрлийн ослуудын хувьд дараах үйлдлийн дарааллаар мэдээлэл өгөх ажлыг хойшлуулалгүйгээр гүйцэтгэнэ:

- Өөрийгөө, бусдын эрүүл мэнд мөн байгаль орчныг аюулд өртүүлэхгүй байх,
- Хэрвээ аюулгүйгээр хийгдэх боломжтой бөгөөд таны сурсан болон ур чадварын

хүрээнд байвал, тоног төхөөрөмж эд материалын хохирлыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авна.

- Ослын хэмжээ болон хор уршгийн хэмжээг үнэлнэ.
- Аваар Устгах Горим (ААГ 001 - Уурхайн Осол) баримтална - Радиогийн 1-р сувгаар “Осол!” “Осол!” “Осол!” гэсэн дуудлага хийнэ.

Эдгээр үйлдлүүдийг илүү дэлгэрэнгүйгээр дараах хэсгүүдэд тодорхой төрлүүдийн ослууд дээр тайлбарласан болно. Уурхайн бүсийн хил заагуудыг харуулсан зургийг Е Хавсралт дээрээс харна уу.

- ЗЭЭГТИЙН Уурхайн бүсэд Онцгой Байдал үүсэх үед авах арга хэмжээ (Үүнд суудлын автомашины ослыг оруулна)

Ослын Газар дээр очсон анхны хүн

- Ослыг мэдээлэгч “Осол - Осол - Осол” гэж мэдээлээд доорх мэдээллүүдийг оруулан аль болох дэлгэрэнгүй, тодорхой мэдээлэл өгнө:
  - » Ослын байршил,
  - » Хэн мэдээлэл өгч байгаа,
  - » Ослын төрөл,
  - » Нэрвэгсдийн тоо, хохирлын төрөл, хэмжээ (түлэгдэлт, унах онхолдох, химийн тэсрэлт г.м)
- Ослын газарт анх очсон хүн уг газартаа үлдэж, радио холбоотой аль болох ойр байрлан шаардлагатай мэдээллүүдийг дамжуулж ослын газарт ирж байгаа хүмүүст зам байршлыг заана.
- Өөрийн сургагдсан хэмжээнд осолд өртөгсдөд тусламж үзүүлнэ.

Ослыг мэдээлэгч

- Ослын мэдээлэл өгч байгаа хүний бүх мэдээллүүдийг баталгаажуулна.
- Энэ хооронд мэдээлэл хүлээн авах хуудсыг бөглөнө.
- Доорх албан тушаалтнуудтай холбоо тогтоож тэд ослын сувгаар мэдээллийг авсан эсэхийг тодорхойлно:
  - » ХАБ-н инженер эсвэл түүнийг орлох хүн,
  - » Уурхайн дарга эсвэл түүнийг орлож байгаа хүн.
  - » Бүх ажиллагсад тоног төхөөрөмжөө аюулгүй газарт байрлуулан онцгой байдлын машинуудад зам нээж өгнө.

АНХААР: Уурхайн бүх талбайг хамарсан онцгой байдал зарлагдахгүй байж болно.

- » Осолд өртсөн бүх техник, тоног төхөөрөмжүүд ослын багийг ирж нөхцөл байдлыг хяналтдаа автал байрандаа хүлээж ХАБ-ийн инженер эсвэл түүнийг орлож байгаа хүн зарласан онцгой байдлыг цуцалтал ямар нэгэн үйлдэл хийхгүй.
- » Осол, аварга өртөөгүй бусад техник, тоног төхөөрөмжүүд диспетчерээс байдал хэвийн болсон, хэвийн ажлын горимд орж болно гэсэн мэдээг

өгтөл хөдөлгөөн хийхгүй хүлээнэ.

- » ХАБ-ийн инженер эсвэл түүнийг орлож байгаа этгээд онцгой байдал намжсан, ослын арга хэмжээ авагдсан, хэвийн горимд орж болно гэсэн зөвшөөрлийг өгтөл радиогийн харилцаануудыг хязгаарлаж, сувгуудыг аль болох чөлөөтөө байлгана.

ХАБ-ийн инженер эсвэл түүнийг орлож байгаа хүн (Ослын Газрын Удирдагч)

- Ослын газар дээр үнэлгээ хийж шаардлагатай хүн хүч, тоног төхөөрөмж болон аюулыг бууруулах боломжууд дээр үнэлгээ хийнэ.
- Боломжит аюул осол гаргах аюултай материал, зээгтийн уурхайн орж, гарах усны ундарга зэрэгт учирч болох аюулыг тооцоолно. Хэрвээ ийм төрлийн болзошгүй аюул, эрсдэл оршин суугчдад нөлөөлөхөөр эсвэл усны эх үүсвэрт аюул байвал уурхайн даргад мэдэгдэж анхааруулах арга хэмжээг яаралтай эхлүүлнэ.
- Цагдаагийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай эсэхэд үнэлгээ хийнэ.
- Уурхайн дарга эсвэл түүнийг орлож байгаа хүнд нөхцөл байдлын тухай мэдээллийг байнга мэдэгдэж байна (15-20 минут тутамд).
- Онцгой байдал намжсаны дараа аврах, аваар устгах багийн хүмүүст “Бүх зүйл хэвийн” гэсэн дохиог өгнө.
- Ослын дараах судалгаа шинжилгээг СРМ-ийн ослын шинжилгээний горимын дагуу хийнэ.

Уурхайн дарга болон Уурхайн инженер, маркшейдер

- Ослын газрын удирдагч Ажилтан болон түүнийг орлож байгаа хүнтэй холбоо барьж доорх асуудлаар зөвлөлдөнө:
  - » Осол гарсан газраас хүмүүсийг аюулгүй газар руу нүүлгэн шилжүүлнэ,
  - » Аюулыг бууруулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангана.
- Улаанбаатар хотын төв оффистой холбоо барьж нөхцөл байдлын тухай мэдээлэл өгч, шаардлагатай бол нэмэлт тусламж, дэмжлэгийг хүснэ.
- Шаардлагатай бүх тусламжийг үзүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ: Тоног төхөөрөмж, автомашины ослын үед осолд орсон тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг зөвхөн хүний амь нас, эрүүл мэндийг аврах шаардлага гарсан эсвэл ажилтанд эмнэлгийн тусламж үзүүлэх зайлшгүй нөхцөл байдлын үед ослын газраас хөдөлгөж болно.

Ослын газар дээр цаашдын цагдаагийн үзлэг шалгалтад хэрэг болохуйц бүхий л ул мөрийг хэвээр нь хадгална. Хуулийн дагуу цагдаа ослын газарт хүрэлцэн ирж ослын газрын болон ослын шалтгааны үзлэг шалгалт хийнэ.

- ЗЭЭГТИЙН Уурхайн оффис болон амьдрах байранд гарсан гал хүснэгт-7

Гал түймэр нь ямар ч газарт гарч болно, гэхдээ ноцтой үр дагавартай гал нь уурхайн

анги, засварын газар, түлшний агуулах, уулын тоног төхөөрөмж, химийн бодисын агуулах, сав, химийн бодисыг уурхай руу тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл зэрэгт гарсан гал болно. Энэ хэсэгт уурхайн ангийн оффис болон амьдрах байрны хэсэгт гарсан галын тухай өгүүлэх болно.

Өдөр шөнийн аль ч үед бэлэн байх ажилтнууд бол ангийн хамгаалалтын албаныхан байна. Хамгаалалтын бүх ажилтнууд сургагдсан байх ёстой бөгөөд Галын Идэвхтэн байх учраас гал сөнөөх анхны мэдлэг чадварыг эзэмшсэн байвал зохино. (Хүснэгт-1 д харуулав.)

Аврах багийн гишүүд мөн орон байрны гал сөнөөхөд сургагдсан галын идэвхтнүүд байна.

Галыг анх илрүүлсэн хүн

- Хэрвээ галыг илрүүлэх үед утаа мэдрэгчүүд автомат дохиоллыг идэвхжүүлээгүй байвал өөрт хамгийн ойр байгаа Галын товчлуурыг дарж идэвхжүүлнэ. Ингэснээр галын дохиолол нь уурхайн харуулын өрөөнд сонсогдохуйц дуугарна.
- Хэрвээ галын байршил байшингаас хол байвал Тал, Гал, Гал” гэсэн дуудлагыг радиогийн 1-р сувгаар өгнө.
- Хэрвээ гал бага хэмжээтэй ба тухайн ажилтан гал унтраах сургалтад хамрагдсан тохиолдолд, мөн өөрт болон бусдад аюул учрахааргүй, зугтах гарцтай бол гал унтраагуул авч галыг унтраах арга хэмжээ авна. (Ав - Чиглүүл - Атга - Займчуул).
- Хэрвээ галын гарал үүсэл нь цахилгаантай холбоотой байвал ус шүршиж унтраахыг хориглоно. Энэ тохиолдолд зөвхөн ABC гал унтраагуул хэрэглэнэ.

Галын Идэвхтэн (ГИ)

- Галын онцгой байдлын талаар мэдээлэл өгсөн тохиолдолд, Галын Идэвхтэн нь галын дохиолол идэвхэжсэн шалтгааныг илрүүлж, гал байгаа эсэхийг нягтална.
- Галыг гарсан бол Галын Идэвхтэн өөрийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулалгүй галыг унтраах боломжтой бол галыг унтраана.
- Харин их хэмжээний гал гарч байвал Галын Идэвхтэн нь ажилтан болон түүнийг орлож байгаа хүнд мэдэгдэж, кемпийн гадна талд байрлах дуут дохиоллыг идэвхжүүлэхийг хүснэ. Мөн галын төрөл, байршил гэх мэт гарч байгаа галын талаар маш тодорхой мэдээлэл өгнө.
- Гаднах дуут дохио идэвхэжсэн тохиолдолд бүх хүмүүс Цуглах цэг рүү очих ёстой.
- Галын Ахмад аль ч сургагдсан Галын Идэвхтэн (ГИ) тухайн гал гарсан газарт очно.
- ГИ (улаан малгай болон гэрэлтдэг хантааз бүхий) нь бусдаас хаалга цохих болон онгойлгоход тусламж хүсэж болно. Гэхдээ өмнө нь гарын алганы хойд



хэсгээр онгойлгох хаалганы цаана их хэмжээний халуун байгаа эсэхийг заавал шалгана.

- Гарын алганы араар хүрэхэд их халуун байвал хаалгыг онгойлгож болохгүй, хаалгыг онгойлговол гэнэт хүчилтөрөгч нэмэгдэн “буцаж гал хүчтэй” авалцаж, нэмэгдэж магадгүй тул гарын доор байгаа ямар нэг хэрэгслээр хаалгыг балбаж доторх оршин суугчийг сэрээнэ.
- Гадагш гарахаасаа өмнө ажилтан бүр өрөөнөөсөө гарахдаа (хэрэв боломжтой бол цонх хаалттай эсэхийг заавал шалгана.
- Өрөөний хаалгыг цохиход ямар ч хариу өгөхгүй байвал, хаалганы цаана халуун байгаа эсэхийг шалгасны дараа таарах түлхүүрээр онгойлгоно.
- Кемпийн бүх оршин суугчдыг хамгийн ойр гарцаар сандралдаж, үймэхгүй гарч “Цуглах цэгт” очин өөрсдийн давхар, А, В, С, V1P болон Менежерүүдийн жигүүрийг тэмдэглэсэн үсгийн өмнө цуваагаар зогсохыг зааварчилна.
- Галын хэмжээ их, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц аюултай нөхцөлд нүүлгэн шилжүүлж байгаа ажилтнуудад бусад үлдсэн ажилтнуудыг сэрээж, хамгийн ойр гарцаар цуглах цэгт очих талаар мэдээлэл өгөхийг хүсэж, туслалцаа авна.
- Энэ үйл явдалтай зэрэгцэн, кемпийн гаднах цуглах цэгт очсон бүх оршин суугчдыг АА-ны Мэргэжилтэн болон ГИ нар бүх ажилтнуудын оршин суух бүртгэлийн дагуу тоолж эхэлнэ.
- АА-ны ажилтан болон ГИ нар бүх оршин суугчид бүрэн цугларсан эсэхийг Галын Ахмадад мэдэгдэнэ.

#### Ажилтнууд болон зочид (Нүүлгэн шилжүүлэлт)

- Ангийн бүх оршин суугч ажилтнууд болон зочид гарц, түүнийг тэмдэглэсэн тод ялгарах ногоон өнгийн тэмдгүүдийг өөрийн байгаа өрөөнөөс аль чиглэлд байгааг үргэлж мэдэж байх үүрэгтэй. Шинэ ажилтнуудад гарцын тэмдгүүдийг сургалтын үеэр зургаар болон бодитоор нь үзүүлсэн байна.
- Дохиолол дугарсан тохиолдолд ажилтнууд болон зочид сандарч үймэлгүйгээр, барилгаас эмх замбараатай гарч цугларах цэгт очно.
- Хэрвээ байран доторх утааны хэмжээ ихэссэн байвал аль болох шаланд ойрхон байж мөлхөж гарах хэрэгтэй.
- Хэрвээ боломжтой бол усаар хөнжил юм уу том алчуурыг норгон мөр толгой дээгүүрээ нөмрөн халуун болон утаанаас өөрийгөө хамгаална.
- Цугларах цэг дээр очиж өөрийн байрыг эзлэн эгнээнд орж эцсийн тооллогод хамрагдах боломжтой зогсоно.
- Уурхайн ахлагч бүх зүйл хэвийн, тарж болно гэсэн зөвшөөрөл өгөхөөс наана цугларах цэгийг орхиж өрөөндөө буцаж орохыг хориглоно.

## ЦУГЛАРАХ ЦЭГ:

- Цуглах цэг нь Кемпийн хашааны баруун урд талд.
- Гэр кемпийн хувьд Цугларах Цэг нь Харуулын Пост байна.

## ХАБ-ийн инженер (Онцгой байдлын талбарын удирдагч)

- Шаардлагатай бол эмнэлгийн ажилтнуудыг онцгой байдлын талбарт татан авчрах арга хэмжээ авна.
- Нөхцөл байдлын үнэлгээ хийгээд гал хязгаарлан, унтраахад шаардагдах техник тоног төхөөрөмжийг зохион байгуулна.
- Онцгой байдлын бүсэд онцгой байдлынхан болон эмнэлгийнхнээс өөр хүн оруулахгүй байх тал дээр хяналт тавина.
- Галын идэштэний тооллогын дүнг кемп менежер оршин суугчдын жагсаалттай тулган үзэж дутуу байгаа хүмүүсийг тодруулан ОБУ-тай зөвлөн ямар ямар өрөөний хүмүүс гэдгийг тогтооно. Кемпэд оршин суугчдын өдөр тутмын шинэчлэгдсэн бүртгэлийг харуул дээр байлгана.
- Гэмтэл бэртэл гарсан бол хүнд гэмтмэн хүмүүст нэн түрүүнд анхан шатны тусламж үзүүлж дараа нь хөнгөн гэмтэлтэй хүмүүст туслалцаа үзүүлнэ.
- Онцгой байдлын талбарт болсон хэрэг явдлыг баримтжуулах арга хэмжээ авна (фото зургаар, гар зургаар гм-ээр).
- Гэрчүүд болон хүндээр гэмтэгсэдийг харгалзаж байсан гэрчүүдийн нэрсийг цуглуулна.
- Шаардлагатай бол өөр Хянах Төв байгуулна.
- Мэргэжлийн ажилчдад (цахилгаанчин, сантехникч, байгаль орчны мэргэжилтэн гм) мэдэгдэн, тэднийг онцгой байдлын газарт цуглуулна.

## Онцгой Байдлын Менежментийн Багт өгөх мэдээлэл

- Нэрвэгдсэн орчноос хүмүүсийг аюулгүй газарт (цугларах цэгт) нүүлгэн шилжүүлсэн байдал,
- Хохирол ослын байдал болон тоо хэмжээ, нүүлгэн шилжүүлэлтийн явц,
- Галын газар татан авчирсан техник төхөөрөмжүүдийг тараан байрлуулсан байдал,
- Байгаль орчинд нөлөөлөх нөхцөл байдал.
- Зээгтийн уурхайн талбар дахь усны нөөц болон амин чухал объектуудад аюул учруулж болох химийн бодисын нөлөөлөл мөн аюултай хий хуралдаж болох нөхцөлүүдийг анхааран ажиллана.
- Уурхайн дарга болон түүний томилсон хүнийг тогтмол шинэчлэгдсэн мэдээллээр хангана (15-20 минут тутам).
- Хүн, эд хөрөнгө, техник тоног төхөөрөмж болон байгаль орчинд аюулгүй болгосон тохиолдолд “Бүх зүйл аюулгүй” гэсэн дохиолол өгнө.

- ГКЭ-ийн ослын шалгалт явуулах горимын дагуу болсон явдлын талаарх шалгалт хийнэ.

#### Уурхайн дарга

- Хяналтын төвд очиж, шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ.
- Хэрэв Хяналтын төв галд автсан бол ХАБ-ийн өөр Хяналтын төвд очно.
- Ажилтан/АААО (Онцгой байдлын газрын ахлагч)-тай доорх арга хэмжээ авагдсан эсэх талаар зөвлөлдөнө.
- Бүх ажилтнууд болон зочид тоологдсон эсэх мөн аюулгүй газар очсон эсэх,
- Хэрэв ямар нэг хүн дутсан бол тэр хүний нэр.
- Аврах эсвэл цэвэрлэх ажиллагаанд зохих тоног төхөөрөмж болон багийг бүрдүүлж өгнө.
- Улаанбаатар дахь Оффисын Ахлах Ажилчдыг мэдээллээр хангах болон/эсвэл тэднээс зохих тусламж хүснэ.
- Шаардлагатай гэж үзвэл удирдлагын төв дээр өөрийгөө орлох хүн томилон ослын газарт очно.

#### Аврах баг (АБ)

- Онцгой байдлын талбарт галын машины хамт очиж нөхцөл байдлын шаардлагын дагуу гал сөнөөх ажлыг хийнэ.
- Онцгой байдлын талбарыг хамгаалалтад авч нөхцөл байдлын шаардлагын дагуу туслалцаа үзүүлнэ.
- Нөхцөл байдлын шаардлагын дагуу аврах ажиллагаа явуулна.

Талбарыг орхин явахын өмнө бүх аж ахуйн объект аюулгүй болсон, хүмүүст болон байгаль орчинд аюул заналхийлэлгүй болсон эсэхийг нягтална.

Улаанбаатар хотоос Зээгтийн уурхай хүртэл аялал гүйцэтгэх үед зам тээврийн осолд өртөх, байгалийн давагдашгүй хүчин зүйл болох цас болон шороон шуурганд өртөх, төөрч осгох зэрэг осол аваараас урьдчилан сэргийлэх зорилгоор "Аяллын үед мөрдөх журам"-ыг боловсруулан батлуулж мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байна.

Энэ журмын хүрээнд шөнийн цагаар аялал гүйцэтгэхгүй, тээврийн хэрэгсэл эвдэрч төөрсөн үед хэрэглэгдэх дулаацуулах хэрэгсэл, анхны тусламжийн хэрэгсэл, нөөц хүнс, сансрын утас зэрэг хэрэгслээс бүрдсэн яаралтай тусламжийн хайрцгийг аяллын машинд байршуулж бэлэн байдал ханган ажиллаж байна.

Мөн уурхайн хээрийн ангид галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын самбар байршуулсан.

### **НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

#### **Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим**

Тус компанийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.

Сэргийлэх бууруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Хоол хүнсний хаягдал бага гаргах</li> <li>• Дахин цэнэглэдэг зай хэрэглэх</li> <li>• Хоёр талаар хэвлэх</li> </ul>
Дахин ашиглах	<ul style="list-style-type: none"> <li>• Мод төмрийн хаягдлыг дахин ашиглах</li> </ul>
Дахин боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Цаас</li> <li>• Хуванцар сав, уут</li> <li>• Хаягдал тос,</li> <li>• Хэвлэгчийн хорны хуурцаг</li> </ul>
Устгах	<ul style="list-style-type: none"> <li>• Газарт булах</li> <li>• Шатаах</li> </ul>

### Хог хаягдлын төрөлжүүлэлт

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүд дээр байрлуулж ашигладаг.

- Хатуу хог хаягдал: цаас, пластмасан сав
- Органик хог хаягдал: Хоол, хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэл
- Шингэн хог хаягдал: Ахуйн бохир ус
- Аюултай хог хаягдал: Шатах тослох материал арчсан даавуу, шатах тослох материалын сав, түүний бөглөө жийрэг

Зураг 22. Ялган ангилах хогийн савууд байршуулсан байдал



## Зураг 23. Хог ялган ангилсан болон уурхайн хог хаягдалыг цэвэрлэсэн байдал



### Түр хадгалалт, тээвэрлэлт

Хог хаягдлыг тухайн үүссэн цэг дээр нь хаягжуулалт бүхий тусгай цэгт битүү хогийн савнуудад ангилан ялгаж тус тусад нь хадгалах ба тээвэрлэлтийг сумын хогны машинаар хийх ба сумын нэгдсэн хогийн цэгт хүргэнэ.

### Хог хаягдлын нөлөөллийг бууруулах арга зам

#### Шингэн хаягдал

Түр хээрийн ангийн ахуйн шингэн хаягдлыг тусгаарлагдсан танканд хадгалж тусгай бодисоор саармагжуулна.

#### Хатуу хог хаягдал

Сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах бөгөөд уурхайн үйл ажиллагаа зогсонги байгаатай холбоотой уурхайн хээрийн ангид 2 хүн тогтмол ажиллаж байна. 1 хүн хоногт 0.3 кг хог хаягдал гаргана гэж тооцвол уурхайд ажиллаж байгаа 2 хүнээс гарах хатуу хог хаягдлын хэмжээ хоногт 0,6 кг, сард 18 кг, жилд 216 кг байна.

Мөн уурхай ажиллах хугацаанд нийт 7 ажилтан ажиллах бөгөөд 1 хүн 0,3 кг хог хаягдал гаргана гэж тооцвол уурхайд ажиллаж байгаа 7 хүнээс гарах хатуу хог хаягдлын хэмжээ хоногт 2,1 кг, сард 63 кг, жилд 756 кг байна. Хатуу хог хаягдлыг сумын байгаль орчны мэргэжилтний заасан хогийн цэгт зөөвөрлөж хаяна.

#### Органик хог хаягдал

Хоол хүнсний хаягдлыг булшилна.

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргатай 2022 оны 01-р сарын 01-ээс 12-р сарын 31-ний өдрийг дуустал нэг жилийн хугацаатай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хаях тэдгээрт хяналт тавих гэрээ байгуулан ажилласан бөгөөд энэ Гэрээний төлбөр 120,000 төгрөгийг төлсөн бөгөөд дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдлыг сумын хогийн цэгт хаяна.

## ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Зээгтийн нүүрсний уурхайн олборлолтын талбайн уурхайн орчим газраас Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний баг агаарын чанарын шинжилгээ хийхэд агаарын чанарын хяналт шинжилгээний түгээмэл тархалттай бохирдуулагч бодис болох хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/, азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийн явцыг MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй гэсэн дүгнэлт гарсан.

